Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэр нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар Төв Азийн Говийн их мужийн өргөрөгийн бүсшилийн цайвар хүрэн хөрсний 5-р тойргийн урд зах болон цөлөрхөг хээрийн бор хөрсний 7-р тойргийн нутагт хамрагдана. Тус уурхайн талбай байгаа газар нь цайвар хүрэн хөрсний бүсэд хамаарна. Газрын гадаргуугийн хувьд нам толгод, гүвээрхэг, долгиорхог тал хөндий, хотос хонхор газрыг хамарсан д.т.д. 1200-1400 м-ийн өндрийн түвшинд орших нутгийг хамаарна. Тус талбай нь нам толгойн орой, хажуу бэлийг хамрах ба энд гүйцэд биш хөгжилтэй цайвар хүрэн болон сайр чулуурхаг нимгэн цайвар хүрэн, ердийн цайвар хүрэн хөрс зонхилон тогтворжсон байна. Цайвар хүрэн хөрсний чийгийн хангамж багатай, хур тунадасны хэмжээ, хуваарилалтаас шууд хамаардаг ба өвөл 2.5-3 м гүн хөлдөнө. Зуны хур борооны ус хөрсөнд дөнгөж 15-20 см гүн нэвчиж, хөрсний профилийн дээд хэсгийг чийглэдэг.

*Цайвар хүрэн хөрс:* Толгодын хатуу суурь чулууны элюви, элюви-делювийн хэмхдэс чулуурхаг хурдас дээр тогтворжих гүйцэд биш хөгжилтэй цайвар хүрэн хөрс нь үе давхарга нимгэнтэй, хөрсний гадарга дээр хад чулуу ихтэй, ургамлын бүрхэц 50-60 % хүрч чулуусаг, хуурайсаг ургамал давамгайлна. Дээр карбонаттай цайвар хүрэн хөрс нь ялзмагт үе давхаргаар илүү зузаан, карбонатын давхаргын хуримтлал 60-70 см зузаан хүрч карбонат ихтэй зэргээр хоорондоо ялгаатай байна.

#### 11-р сарын 03-ны шинжилгээ

Хөрсний морфологи тогтоцын хувьд цайвар хүрэн өнгөтэй, нягт, жижиг чулуутай, ургамлын үндэстэй, ургаман бүрхэвч 50%, хуурай, бүтэц алдагдсан, үе давхарга хоорондын шилжилт тод байна.

Хөрс нь сул хүчиллэгээс сул шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, хөдөлгөөнт фосфорын хангамж бага зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Хөрсний лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд ялзмагийн хэмжээ 0.20%, хөрсний рН 8.7, хөдөлгөөнт фосфор 25.3мг байгаа зэрэг нь хөрсний хими шинж чанарын түвшин болон ургамал ургах орчин хангалттай сайн байна. 2025 оны 11-р сарын 03-ны өдөр уурхайн ойр орчмын 2 цэгээс хөрсний дээжлэлт хийж “Нарт шуун консалтинг” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлээ.

Хүснэгт 16. Хөрсний химийн үндсэн шинж

Дээж	Чийг	pH	Ялзмаг, %	Аммоны азот (NH <sub>4</sub> -N) мг/кг	Нитратын азот (NO <sub>3</sub> -N) мг/кг	Фосфор (NH <sub>4</sub> -N) мг/кг	Сульфат (SO <sub>4</sub> ) мг/кг
Уурхайн салхин дээр 500 м	0.67	8.04	0.27	16.2	20.4	32.3	503.9
Уурхайн салхин доор 500 м	0.59	9.13	0.16	5.1	8.0	27.8	86.0
Ажилчдын кемп	0.39	9.02	0.20	29.6	8.1	21.3	80.3
Мод үржүүлэгийн орчмоос	0.50	8.92	0.18	26.2	7.6	20.0	67.9

Хөрсний механик бохирдол буюу хүнд металлын агууламжийг төслийн талбайд 4 цэг сонгон авч шинжлүүлэхэд ЗДХ-ээс хэтэрсэн буюу бохирдолтой хөрс илрээгүй байна.

Хүснэгт 17. Хөрсний хүнд металлын сорьц

№	Сорьц авсан цэгийн нэр	Хүнд металл мг/кг						
		Cd /кадми/	Pd /хар тугалга/	Hg /мөнгөн ус/	Cr /хром/	Zn /цайр/	Cu /зэс/	Sr /стронци/
		мг/кг						
1	Уурхайн карьер орчим	2	23	<0.005	<0.05	<0.005	31	545
2	Ахуйн хэрэглээний хогийн цэг орчим	1	14	<0.005	<0.05	<0.005	28	622
<b>MNS 5850:2019 /ЗХД/</b>		<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>800</b>

### 3.3. Усны химийн шинжилгээ

#### 11-р сарын 03-ны шинжилгээ

Төслийн ахуйн хэрэглээний усыг гүний худгаас ашигладаг бөгөөд уг худгаас дээжлэлт хийсэн усны химийн задлан шинжилгээний дүнг дараах хүснэгтэд харууллаа. Шинжилгээний дүнд худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, хатуу ус байна гэж гарчээ. Мөн уурхайн карьерийн шүүрлийн уснаас хүнд металлын бохирдлыг шинжлүүлсэн.

Хүснэгт 18. Худгийн усны ерөнхий шинжилгээ

Сорьцын нэр	pH	ЕС µS/cm	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг- экв/л
Дундговь аймаг Өлзийт сум 4-р баг Хайлуур жоншны орд, гүний худаг	7.83	2110	316	217	50.7	43.2	363	482	1472	6.08
<b>MNS 0900:2018</b>	<b>6.5-8.5</b>	<b>1000</b>	<b>500</b>	<b>350</b>	<b>100</b>	<b>30</b>	-	-	-	<b>7.0</b>

Хүснэгт 19. Уурхайн ахуйн хэрэглээнээс гарах бохир усны шинжилгээ

Сорьцын нэр	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH <sub>4</sub> -N мг N/л	NO <sub>2</sub> -N мг N/л	NO <sub>3</sub> -N мг N/л	PO <sub>4</sub> мгP/л	Fe мг/л	F мг/л
Дундговь аймаг Өлзийт сум 4-р баг Хайлуур жоншны орд, гүний худаг	6.8	1.7	<0.01	0.007	5.89	0.008	<0.01	4.02
<b>MNS 0900:2018</b>	-	-	<b>1.5</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.3</b>	<b>0.7-1.5</b>

Хүснэгт 20. Шүүрлийн усны хүнд металлын шинжилгээ

№	Лаб №	Дээж №	Элемент, мг/л					
			Ni	Cd	Pb	Zn	Cr	Cu
Blank			<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
1	24/4451	Ус-1	ND	ND	2.54	8.29	ND	0.77
<b>Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт</b>			<b>MNS 6148:2010</b>					

### 3.4. Ургамлын аймаг

Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг нь газарзүйн мужлалаар Төв Азийн говийн их мужид, газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр ухаа гүвээт тэгш талын өндөрлөг хэв шинжид багтана. Талбайн хэмжээнд хамгийн өндөр өргөгдсөн цэг нь


талбайн урд, зүүн урд захаар орших далайн түвшинээс дээш 1350м-т, хамгийн намхан цэг нь 1300 м-ийн өндөртэй байх бөгөөд харьцангуй өндөршилт 50-150м орчим байна. Толгодууд, гүвээ нь мөлгөр оройтой, аажим налуу хажуутай, уужим тавиу өргөн хөндий хөгжсөн байдаг. Говь, хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Хонхор хотгор газруудаар хужир тойром мараалаг хөрс элбэг тархсан байдаг. Хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн монгол өвст- бударганат хээрийн бүсэд багтана. Ус чийг багатай, салхитай учир ургамлын бүрхүүл сийрэгдүү байдаг. Харгана, бударгана зэрэг бутлаг ургамал, таана, хөмөл, монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг. Ургамал ерөнхийдөө сийрэг боловч тачирхан, тэжээллэг чанар сайтай учир бэлчээрийн багагүй ач холбогдолтой.

Хүснэгт 21. Түгээмэл тархацтай ургамлын жагсаалт

Төрлийн тоо	Зүйлийн тоо	Зүйлийн шинжлэх ухааны болон Монгол нэр		Нийт зүйл
1. Зээргэний овог -Ephedraceae				1
1	1	<i>Ephedra sinica</i>	Нангиад Зээргэнэ	Элбэг
2. Үетний овог- Graminae				8
2	2	<i>Achnatherum splendens</i>	Гялгар Дэрс	Цөөн
3	3	<i>Stipa krylovii</i>	Крыловын Хялгана	Элбэг
	4	<i>Stipa gobica</i>	Говийн хялгана	Элбэг
	5	<i>Stipa glareosa</i>	Сайрын хялгана	Элбэгдүү
4	6	<i>Cleistogenes songorica</i>	Дэрвээн Хазаар өвс	Элбэгдүү
5	7	<i>Agropyron cristatum</i>	Саман Хиаг	Элбэгдүү
6	8	<i>Aristida heymanii</i>	Нохой шивээ	Элбэгдүү
7	9	<i>Elymus chinensis</i>	Нангиад Цагаан суль	Цөөн
3. Сарааны овог -Liliaceae				4
8	10	<i>Allium polyrhizum</i>	Таана	Элбэг
	11	<i>Allium.mongolicum</i>	Хөмөл	Цөөн
	12	<i>Allium anisopodium</i>	Сарвуун сонгино	Элбэг
9	13	<i>Asparagus gobicus</i>	Говийн хэрээ нүд	Ховор
4. Цахилдгийн овог- Iridaceae				1
10	14	<i>Iris lacteal</i>	Цагаалин цахилдаг	Ховор
5. Тарнын овог- Polygonaceae				1
11	15	<i>Rheum nanum</i>	Намхан гишүүнэ	Ховор
6. луулийн овог- Chenopodiaceae				7
12	16	<i>Chenopodium album</i>	Цагаан лууль	Элбэгдүү
13	17	<i>Anabasis brevifolia</i>	Түжгэр баглуур	Элбэгдүү
14	18	<i>Eurotia ceratoides</i>	Орог тэсэг	Элбэгдүү
15	19	<i>Salsola collina</i>	Толгодын бударгана	Элбэг
	20	<i>Salsola passerine</i>	Бор бударгана	Элбэг
	21	<i>S.pestifera</i>	Өргөст бударгана	Элбэг
16	22	<i>Corespermum mongolicum</i>	Монгол хамхуул	Цөөн
7. Caryophyllaceae				1
17	23	<i>Stellaria dichotoma</i>	Ацан ажигана	Элбэг
8. Уруул цэцэгтний овог - Cruciferae				1
18	24	<i>Lepidium densiflorum</i>	Бөөн цэцэгт цангуу	Цөөн
9. Сарнайн овог -Rosaceae				1
19	25	<i>Potentilla bifurca</i>	Имт гичгэнэ	Цөөн

20	26	<i>Potanina mongolica</i>	Хулан хойрог	Элбэгдүү
10. буурцагтны овог - Leguminosae				3
21	27	<i>Caragana leucophloea</i>	Алтан харгана	Цөөн
	28	<i>C.stenophylla</i>	Нарийн навчит харгана	Цөөн
22	29	<i>Astragalus galactites</i>	Цагаан хунчир	Элбэгдүү
11. Хотирын овог - Zygophyllaceae				2
23	30	<i>Peganum nigellastrum</i>	Харлаг үмхий өвс	Цөөн
24	31	<i>Nitraria sibirica</i>	Сибирийн хармаг	Ховор
12. Сэдэргэний овог - Convolvulaceae				1
25	32	<i>Convolvulus ammanii</i>	Амманы сэдэргэнэ	Элбэг
13. нийлмэл цэцэгтний овог - Compositae				6
26	33	<i>A.pectinata</i>	Шүлхий шарилж	Элбэгдүү
	34	<i>A.scoparia</i>	Ямаан шарилж	Элбэгдүү
	35	<i>A.frigida</i>	Агь	Элбэг
	36	<i>A.adamsii</i>	Адамсын шарилж	Цөөн
27	37	<i>Saussurea.salsa</i>	Марцны банздоо	Цөөн
28	38	<i>Scorzonera pseudodivaricata</i>	Хуурамч хависгана	Ховор

Судалгааны явцад хээржүү цөлд Төв Азийн сөөгөнцөр ургамлууд бүлгэмдлийн зонхилогч болдог шинж, мөн зонхилогч зүйлүүд нь олон янзын бүлгэмдэл үүсгэдэг онцлог нь /И.Түвшинтогтох 2005/ тод ажиглагдсан. Ялангуяа доминант нь *Anabasis brevifolia*, *Reaumuria songorica*, *S.gobica*, *Stipa glareosa*, *Salsola passerine*, *Allium polyrrhizum*, *Cleistogenes songorica*, *Potanina mongolica*, *Zygophyllum xanthoxylon*, *Ajania fruticulosa* зонхилон тархаж байна. Тус нутгийн ургамлын ургац дунджаар 0.1-0.6 ц/га байна.



Зураг 15. Ургамлан нөмрөг бүрдүүлж буй ургамлын тоо

Судалгаагаар зүйлийн бүрдэл нь 13 овог 28 төрлийн түгээмэл тархацтай, 39 зүйл ургамал талбайн орчимд бүртгэгдлээ. Эдгээрээс тус бүр 1 зүйл ургамлын тархацтай 7 овгийн 7 зүйлийн ургамал нийт нөмрөгт 21.1 хувийг эзэлж, нийт ургамлан нөмрөгийн 80 орчим хувийг 6 овгийн 30 гаруй зүйл ургамал бүрдүүлж байна.

Судалгаагаар бүртгэгдсэн ургамлуудын нөмрөг бүрдүүлэх байдлыг бүтцийн талаас нь авч үзвэл үетний овог- *Graminae* зүйлийн бүрэлдэхүүнд 22%, нөмрөгт 23%-ийг, луулийн овог- *Chenopodiaceae* зүйлийн бүрэлдэхүүнд 19%, нөмрөгт 23 хувийг, нийлмэл цэцэгтний овог- *Compositae* зүйлийн бүрэлдэхүүнд 16%-ийг нөмрөгт 14%-ийг, сарааны овог- *Liliaceae* зүйлийн бүрэлдэхүүнд болон нөмрөгт 11%-ийг тус бүр эзэлж ургамлан нөмрөгийн шинж бүрдүүлэх үндсэн үүргийг гүйцэтгэж байна.



Зураг 16. Нөмрөг ургамлын зүйлийн бүрэлдэхүүний болон нөмрөгийн бүтцүүд

Зонхилох сөөг нь (*C. tibetica* ба *C. leucosephala*) гэсэн хоёр зүйл харгана юм. Нам өвслөг ургамал нь хоёр зүйл хялгана (*Stipa gobica* ба *S. glareos*) өргөн тархсан. Лицензийн талбайд нутгийн ургамалжилт нь ургамлан нөмрөгт гадаргуугийн 8 - 20%-ийг эзлэх ба 0.8 метрээс илүүгүй өндөр, ганд тэсвэртэй олон наст сөөгүүдээс голчилон бүрдэнэ. Нэг наст өвслөг ургамал нь улирлын шинж чанартай хур тунадасны хэмжээнээс шалтгаалан ургана.

Нутгийн ургамалжилтын үндсэн шинж нь Говь хээрийн ургамлын зүйлийн бүлгэмдэл нь *Anabasis brevifolia* + *Allium mongolicum*, *Salsola passerine* + *Reamuria sp* + *Sympegma regelii* (+*Potaninia mongolica*) зэрэг зүйлүүдээс тогтоно. Ус тогтох боломжтой марзлаг газарт харганат, хялганат бүлгэмдэлд шилжинэ.

Хүснэгт 22. Судалгааны талбайн ургамлын бүлгэмдлүүд


№	Бүлгэмдлийн нэр	Бүрхэвч, %	Дундаж өндөр (см)	Зүйл (цэг бүрт)	Зонхилох зүйл (25мX25м тутамд)
1	<i>Anabasis brevifolia</i> + <i>Allium mongolicum</i> , (гадаргатай ойролцоо гүехэн ус)	18-23	15-20	23	<i>Anabasis brevifolia</i> , <i>Caragana leucocephala</i> , <i>Salsola passerine</i>
2	<i>Salsola passerine</i> + <i>Reamuria sp</i> (+ <i>Potaninia mongolica</i> ) (Марзлаг хөндийн)	35-40	25-80	17	<i>Allium mongolicum</i> , <i>Artemisea frigid</i> , <i>A.s</i>

Энэ нутгийн өргөн хөндийнүүд карбонатлаг, мараалаг хөрс зэргээс ургамлын бүлгэмдлийн хуваарилалт шалтгаалж байна. Мараалаг бус мараалагтай холигдсон хөнгөн хөрсөнд хазаар- хялганат бүлгэмдэл *Caragana leucophloea* *C.Stenophylla* гэсэн 2 зүйл харганатай хамтарна. Элсэнцэр хөрстэй бол харгана- үетэнт бүлгэмдэл бий. Толгодын хайргархаг хөрсөнд олон наст бударгана- хялганат, хэрэв бага зэрэг мараалаг хөрстэй орчинд баглуур- хялгана- сонгинолог ургамалт, сонгинолог- хялганат,

сонгинолог- бор бударгана тохиолдоно. Талбайн уурхайн ашиглалын үйл ажиллагаанаас болон кемпийн байгууламжийн улмаас зарим хэсэгт ургамлан нөмрөг доройтсон байна.

Хонхор газарт хялгана- улаан, бударгана- бор, бударганат заримдаа шар бударганат бүлгэмдэлтэй. Энд зонхилогч нь *Stipa glareosa*, *Stipa gobica*, *Ajanina frifida*, *Ceratoides papposa*, *Allium polyrrhizum*, *A.mongolicum*, *Salsola passerina*, заримдаа *Kalidium gracile*, дэд зонхилогчоор *Anabasis brevifolia* *Stipa g/g*, *Caragana leucophleoa* *C.Stenophylla*. *Cerotoides papposa*, *Allium*, *Reumuria songorica* зэрэг болно.

Ургамлан нөмрөгийн ашиглалтын одоогийн байдалд нөмрөг ургамлын чанарын үзүүлэлт бэлчээрийн өндөр ач холбогдлоо хадгалсан хэвээр байна. Зүйлийн бүрэлдэхүүн 6%-ийг 2 зүйл ашигт ургамал /*Allium polyrrhizum*, *Allium.mongolicum*/ талбай орчимд ургамлан нөмрөгт 5%-ийн арвитай байгаа бол 28 зүйлийн бэлчээрийн ургамлан нөмрөгт 72%-ийн арвитай байна.



Зураг 17. Ургамлан нөмрөгийн чанарын үзүүлэлт бүрхэцээр болон зүйлийн бүрэлдэхүүнээр

## ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2025 он 09 дугаар сарын 25 өдөр

№ 05

Рашаант

### Нэг . Нийтлэг үндэслэл

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2,6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 40 тоот тогтоолыг тус тус үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

### Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас **Дундговь аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ыг** төлөөлж Засаг дарга **Адъяадорж** овогтой **Жавхлан** нөгөө талаас Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баруун сэлбийн 5-р байр, 504 тоот хаягтай, **9011113121** тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, **5175933** тоот регистрийн дугаартай Дундговь аймгийн Өлзийт суман дахь “Өлзийт -1 ” нэртэй газарт ашиглалтын **МУ-019018** тусгай зөвшөөрөл эзэмшигч “**Межикбридж**” ХХК-ны захирал **О.Эгшиглэн** нар харилцан тохиролцож 2025 оны 12 сарын 31- ний өдөр хүртэл энэхүү гэрээг байгуулав.

### Гурав. Төлбөр тооцсон байдал

Өлзийт сумын ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 40 дүгээр тоот тогтоолын 25-д заасны дагуу уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжид хог хаягдал гаргасны 1 сарын төлбөрийг **148.000** төгрөгөөр тооцож ашиглалтын ажил явагдах 4 сард нийт 592,000 төгрөгөөр тооцов.

### Дөрөв. Сумын ЗДТГ эрх, үүрэг

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх
3. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

### Тав. Иргэн ААН байгууллагын эрх үүрэг

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.
2. ААН байгууллага нь хог хаягдал гарсан төлбөрөө 2 дугаар улиралд багтаан ноогдуулсан төлбөрийн дагуу нэхэмжлэхээр төлнө. /төрийн сан банк/

3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх.
10. Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газарт ноогдуулсан төлбөрийн дагуу нэхэмжлэхээр төлбөрөө төлөх.

**Зургаа. Гэрээний хариуцлага**

1. Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд ер авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

ДУНДГОВЬ АЙМАГ ӨЛЗИЙТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА /А.ЖАВХЛАН/

УТАС: 88887527

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

“МЭЖИК БРИДЖ” ХХК-ны захирал  
О.ЭГШИГЛЭН

Гарын үсэг: \_\_\_\_\_

УТАС: 98999999



**МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**

**ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 2251100073391**

ТТД / Регистр:	<b>47900834686 / 9033076</b>
Татвар төлөгчийн нэр:	<b>Дундговь аймгийн Өлзийт сумын засаг даргын тамгын газар</b>
Татварын төрөл:	<b>01030723 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж</b>
Харъяалах татварын алба:	<b>Дундговь / Өлзийт</b>
Төлсөн дүн:	<b>592,000.00</b>
Гүйлгээний огноо:	<b>2025-10-30 09:11:00</b>
Гүйлгээний утга:	<b>194597 - байцаагч үүсгэв;;99999999</b>
Татварын данс:	<b>100080800947 / Ду.Өл Хог хаягдлын хураамж</b>
Төлөлтийн хэлбэр:	<b>МТА</b>





Дундговь аймгийн  
 байгаль орчны газар

**УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2025 оны 06 -р  
 сарын 13 -ны өдөр

Дугаар Е-2506-000058

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар**

Оноосон нэр: Мэжикбридж ХХК  
 Улсын бүртгэлийн дугаар:  
 Регистрийн дугаар: 5175933  
 Захирал: Эгшиглэн  
 Холбоо барих дугаар: 98999999  
 Факс :  
 И-мэйл хаяг :

**2.Төслийн нэр байршил**

Төслийн нэр: Цогзол уулын хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах  
 Байршил: Дундговь, Өлзийт, 4-р баг, Дэрт 1  
 Харьяалагдах сав газар: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар  
 Хамаарах салбар: Үүл уурхай  
 Төслийн дэлгэрэнгүй: Цогзол уулын хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах

**3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр**

Мэжикбридж

**4. Ажиллах горим, хүчин чадал**

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
1	2 ээлжээр	180	10	10

**5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ**

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	25.0	хоногт 1хүн	Үүлын ажил нь жилд 6 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 10 цагаар явагдана /2025 оны БОМТ 6-р хүүдас/
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	24000.0	м2	ТЭЗҮ-ийн тодотголыг 2021 онд шинэчлэн батлуулсан цаашид үргэлжлүүлэн

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
			ашиглахад Өлзийт-1 хүдрийн биетэд 2025 онд 467.2 мян.м3 хөрс хуулж, 90.57 мян.тн хүдэр олборлохоор байна. /VAT 10-р хуудас, ТЭЗҮ-33-р хуудас, БОМТ-8-р хуудас/ Үүрхайн усны хэрэглээ ТЭЗҮ-78 дугаар хуудас.

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Ахуйн хэрэгцээнд	3.0	259.2	Усны газрын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр Цогзол уулын хайлуур жоншны ордыг ил аргаар олборлох төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах унд ахйн болон зам талбайн тоосжилт дарах 53.1 м3хон усыг өөрийн эзэмшлийн 3.5 л/сек буюу 302,4 м3/хон ундрагатай гүний худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ:	Солонгон төгөл ХХК
Холбоо барих:	99056979
Нэмэлт мэдээлэл:	-

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
--------------------	------------------	-------------

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
---------------------	-------------------------------	------------------	--------------------------

10. Онцгой нөхцөл

Ундны усны худгуудад усны бичил элементийн шинжилгээг жилд 2- оос доошгүй удаа хийлгэх  
 Усан орчныг тогтмол цэвэрлэж байх  
 Шүүрлийн ус гарвал ус ашиглуулах дүгнэлт дээр нэмэлт тодотгол оруулах.

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	25	хоногт 1 хүн	0.05	160.0	Хоног	200.00	0.00	200.00
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	24000	м2	0.002	160.0	Хоног	7,680.00	0.00	7,680.00
<b>Нийт</b>						<b>7,880.00</b>	<b>0.00</b>	<b>7,880.00</b>

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	200.00	Газрын доорх ус	0.0	88.80	17,760.00	0.0	17,760.00
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	7680.00	Газрын доорх ус	0.0	185.00	1,420,800.00	0.0	1,420,800.00
<b>Нийт</b>	<b>7,880.00</b>				<b>1,438,560.00</b>		<b>1,438,560.00</b>

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

Технологид ашигласан усаа цэвэршүүлэн эргүүлэн ашиглах

14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

-Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг Дундговь аймгийн төрийн сан банкны MN280090100080000944 тоот дансанд төвлөрүүлнэ.

-Өлзийт сумын Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах /"Усны тухай" хуулийн 28.6-р зүйл/

-Худаг тооллууржуулах

-Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч ажиллах /Усны тухай хуулийн 31.2-р зүйл/

- Ус ашиглалтын мэдээ тайланг 11-р сарын 05-нд багтаан аймгийн Байгаль орчны газарт ирүүлэх.

**Боловсруулсан:**

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

Боловсруулсан огноо:

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 10 сарын 02-ны өдөр

Дугаар 02

Рашаант

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 29.1-д заалт Дундговь аймгийн Байгаль орчны газрын 2020 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн 31 тоот дүгнэлт, Засаг даргын 2025 оны 10 сарын 02-ны өдрийн А/113 тоот захирамжийг үндэслэн ус ашиглуулагчийг төлөөлж Өлзийт сумын Засаг дарга А.Жавхлан, ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 5-504 тоот хаягтай 9011113121 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5175933 тоот регистрийн дугаартай Дундговь аймгийн Өлзийт суман дахь “Өлзийт -1” нэртэй газарт ашиглалтын МҮ-019018 тусгай зөвшөөрөл эзэмшигч “Мэжикбридж” ХХК-ны захирал О.Эгшиглэн нар энэхүү гэрээг 2025 оны уулын ажлын хүрээнд байгуулав.

### Хоёр. Усны эх үүсвэрийн мэдээлэл

2.1. Ус ашиглах зориулалт: Унд ахуйн хэрэгцээ, Төслийн талбайд 2025 онд ашиглалтын үйл ажиллагааны хүрээнд зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус

2.2. Ашиглах усны хэмжээ: 53,1 м<sup>3</sup>

2.2.1. унд-ахуй болон зам талбайн тоосжилт дарахад 53,1 м<sup>3</sup>

Нийт 53,1 м<sup>3</sup>

2.2.2. үйлдвэрлэлд хэрэглэхгүй

2.3. Усны чанар, найрлага: Газрын доорх ус, шинжилгээ хийлгээгүй.

2.4. Усны эх үүсвэрийн:

Байршил : Унд ахуйн хэрэглээний болон зам талбайн тоосжилт дарахад ашиглах усаа 6,0 л/сек буюу 302,4 м<sup>3</sup> ундаргатай “Баруун булаг” нэртэй гүний худгаас, ашиглана.

2.5. Хаягдал усны хэмжээ: Хаягдал ус гарахгүй. Стандартын шаардлага хангасан

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ.

2.7. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.8. Усны тоолуур байхгүй.

2.9. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: шоо метр- 25 хүн \* 0,05л/хон\*160 хон = 200 м<sup>3</sup> /ажиллах нийт хугацаанд – унд ахуйн усны хэрэгцээ

24000 м<sup>2</sup> \* 0,002м<sup>3</sup> /160 хоног = 7680 м<sup>3</sup> /хайгуулын өрөмдлөгт ашиглах ус

Нийт ашиглах усны хэмжээ: 200 м<sup>3</sup>+7680 м<sup>3</sup> = 7880 м<sup>3</sup>

200 м<sup>3</sup> x 88,80 = 17,760.00 төгрөг

7680 м<sup>3</sup> х 185.00 = 1,420,800.00

Нийт төлөх **1,438,560.00** /Хоёр зуун хорин хоёр мянган төгрөг/-ийг Дундговь аймгийн төрийн сан банкны **100080000944** тоот дансанд төвлөрүүлэх.

#### Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1; 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### Дөрөв. Бусад

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцлаж болно.
  - 4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн
  - 4.5.2. аль нэг тал татан буугдсан бол.
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### Ус ашиглуулагчийг төлөөлж:

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
...../А.ЖАВХЛАН/

Харилцах утас: 88887527



Ус ашиглагчийг төлөөлж:  
“МЭЖИКБРИДЖ” ХХК-ны захирал  
...../О.Эгшиглэн /  
/Гарын үсэг/

Хаяг Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 5-504 тоот  
Харилцах утас: 98999999



Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2025.10.07 11:21:06

**Шилжүүлгийн мэдээлэл**

Журналын №: 284468233

Системийн огноо: 2025.10.07

Нэр: МЭЖИКБРИДЖ ХХК

<b>Илгээгч</b>	Дансны дугаар: 452732723	Нэр МЭЖИКБРИДЖ ХХК	Дүн 1,438,560.00 MNT	Ханш 1.00
/ нэг сая дөрвөн зуун гучин найман мянга таван зуун жаран төгрөг /				
<b>Хүлээн авагч</b>	Банкны дугаар: 90 Дансны дугаар MN280090100080000944	Банкны нэр Төрийн сан Нэр Ду.Ус ашигласны төлбөр	1,438,560.00 MNT	1.00

Гүйлгээний утга:

ЕВ -Мэжикбридж ххк 5175933

**Танд баярлалаа**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:


Тамга:

Огноо: \_\_\_\_ Он \_\_\_\_ Сар \_\_\_\_ Өдөр

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

“МЭЖИК БРИДЖ” ХХК-НИЙ “ЦОГЗОЛ УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ 3-Р БАГИЙН НУТАГТ “ШАР ХОШУУ” НЭРТЭЙ ТАЛБАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ АКТ

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

1. Байршлын мэдээлэл																																						
1.1.	Аймаг, нийслэлийн нэр	Дундговь аймаг																																				
1.2.	Сум, дүүргийн нэр	Өлзийт сум																																				
1.3.	Газрын нэр	Шар хошуу																																				
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын мэдээлэл																																						
2.1	Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар	“Межик бридж” ХХК 5175933																																				
2.2	.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-019018																																				
2.3	Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га)	Хууль бус олборлолт, эзэн холбогдогч тодорхойгүй																																				
2.4	Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	үгүй																																				
3. 2025 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл																																						
Техникийн нөхөн сэргээлт - Талбайн хэмжээ (5.0 га) - Зардлын хэмжээ 13 723 000 (төгрөгөөр)		Биологийн нөхөн сэргээлт - Талбайн хэмжээ (га) - Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод, сөөг, ургамлын зүйлийн нэр, ургамалжуулсан байдал - Зардлын хэмжээ (төгрөгөөр)																																				
4. Орон зайн мэдээлэл																																						
5.1	Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг Хавсаргав	5.2. Хэмжилт, зураглал - Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр: “Межик бридж” ХХК ХХК Байгаль орчны мэргэжилтэн Д.Чимэдцэрэн - Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж: ArcGis, Гар GPS - Холбогдох утас: 99056979 Гарын үсэг:																																				
5.3	Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол 	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Өргөрөг</th> <th>Уртраг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="3">Техникийн нөхөн сэргээлт</td> </tr> <tr> <td>1</td> <td>44°25'56.00"N</td> <td>106°03'34.00"E</td> </tr> <tr> <td>2</td> <td>44°25'55.00"N</td> <td>106°03'33.00"E</td> </tr> <tr> <td>3</td> <td>44°25'55.00"N</td> <td>106°03'26.00"E</td> </tr> <tr> <td>4</td> <td>44°25'52.00"N</td> <td>106°03'26.00"E</td> </tr> <tr> <td>5</td> <td>44°25'51.00"N</td> <td>106°03'31.00"E</td> </tr> <tr> <td>6</td> <td>44°25'52.00"N</td> <td>106°03'35.00"E</td> </tr> <tr> <td>7</td> <td>44°25'55.00"N</td> <td>106°03'44.00"E</td> </tr> <tr> <td>8</td> <td>44°25'57.00"N</td> <td>106°03'42.00"E</td> </tr> <tr> <td>9</td> <td>44°25'58.00"N</td> <td>106°03'39.00"E</td> </tr> <tr> <td>10</td> <td>44°25'56.00"N</td> <td>106°03'35.00"E</td> </tr> </tbody> </table>	№	Өргөрөг	Уртраг	Техникийн нөхөн сэргээлт			1	44°25'56.00"N	106°03'34.00"E	2	44°25'55.00"N	106°03'33.00"E	3	44°25'55.00"N	106°03'26.00"E	4	44°25'52.00"N	106°03'26.00"E	5	44°25'51.00"N	106°03'31.00"E	6	44°25'52.00"N	106°03'35.00"E	7	44°25'55.00"N	106°03'44.00"E	8	44°25'57.00"N	106°03'42.00"E	9	44°25'58.00"N	106°03'39.00"E	10	44°25'56.00"N	106°03'35.00"E
№	Өргөрөг	Уртраг																																				
Техникийн нөхөн сэргээлт																																						
1	44°25'56.00"N	106°03'34.00"E																																				
2	44°25'55.00"N	106°03'33.00"E																																				
3	44°25'55.00"N	106°03'26.00"E																																				
4	44°25'52.00"N	106°03'26.00"E																																				
5	44°25'51.00"N	106°03'31.00"E																																				
6	44°25'52.00"N	106°03'35.00"E																																				
7	44°25'55.00"N	106°03'44.00"E																																				
8	44°25'57.00"N	106°03'42.00"E																																				
9	44°25'58.00"N	106°03'39.00"E																																				
10	44°25'56.00"N	106°03'35.00"E																																				
Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр <i>shape.file</i> үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.																																						
6. Мэдээллийн сангийн бүртгэл																																						

Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн [www.eic.mn](http://www.eic.mn) цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.  
 Жич: Мэдээллийн санд бүртгээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.  
 Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал:  
 Гарын үсэг:  
 Огноо:

Нэмэлт мэдээлэл: Өлзийт сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орших Шар хошуу нь хууль бус ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон газар юм.

Нөхөн сэргээлтийн ажил нь холбогдох хууль, журам, стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт:

“Мэжик бридж” ХХК нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу “Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт” арга хэмжээний хүрээнд “Шар хошуу” нэртэй 5.0 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэснийг хүлээн авав.

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга:

  
 .....  
 (гарын үсэг)

А.Жавхлан /Өлзийт сумын засаг дарга/

Нарийн бичгийн дарга:

  
 .....  
 (гарын үсэг)

М.Ганчимэг /Байгаль орчны хяналтын байцаагч /

Гишүүд:

  
 .....  
 (гарын үсэг)

Б.Дашням /3-р багийн засаг дарга/

  
 .....  
 (гарын үсэг)

Б.Ганбаатар /Иргэний төлөөлөл/

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

  
 .....  
 (гарын үсэг)

О.Эгшиглэн /“Мэжик бридж” ХХК-ийн гүйцэтгэх захирал/



## “НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
 Утас: (976)-99176123, 99231836

E-mail: [nartconsulting@gmail.com](mailto:nartconsulting@gmail.com)

№ 25/11-13/-1

Захиалагч: “Мэжик бридж” ХХК

Дээж авсан цэг: Дундговь аймаг Өлзийт сум

Сорьц авсан огноо: 2025 оны 11 сар 03 өдөр

Уст цэгийн төрөл: Гүний худаг

Харилцах утас:

Аргын стандарт: Аргын стандарт: MNS1097:2023, MNS ISO 7888:1999, MNS ISO 9297:2005

### 1. УСНЫ ХИМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Катион	1 дм <sup>3</sup>			Анион	1 дм <sup>3</sup>		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Ca <sup>++</sup>	64.00	3.19	21.41	CO <sub>3</sub> <sup>-</sup>	0.00	0.00	0.00
Mg <sup>++</sup>	41.00	3.37	22.61	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	540.00	8.85	59.31
Fe	0.00	0.00	0.00	Cl <sup>-</sup>	168.00	4.74	31.76
K <sup>+</sup>	5.00	0.13	0.86	SO <sub>4</sub> <sup>-</sup>	57.00	1.19	7.96
Na <sup>+</sup>	189.00	8.22	55.12	NO <sub>3</sub> <sup>-</sup>	9.00	0.15	0.97
Дүн	299.00	14.92	100.00	Дүн	774.00	14.92	100.00

Анион катионуудын нийлбэр:

(Σ<sub>A+K</sub> 1073 мг/л

HCO<sub>3</sub><sup>-</sup>-ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр: 803 мг/л

**Физик үзүүлэлтүүд**

Өнгө: 0-өнгөгүй

Үнэр: 0-үнэргүй

Булингар: Булингаргүй

Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 665 ppm

Ерөнхий хатуулаг: 6.56 мг-экв/л

/ хатуу ус /

Урвалын орчин: pH- 7.85

Цахилгаан дамжуулах чадвар:

EC -1.587 ds/m

TDS: 789 ppm

$$M(1.07) = \frac{HCO_3 \ 59 \ Cl \ 32 \ [SO_4 \ 8]}{Na \ 55 \ [Mg \ 23 \ Ca \ 21]}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, натрийн бүлэг, III төрлийн давсархаг буюу их эрдэсжилттэй, хатуу ус.

### 2. УСНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж	Усны хүнд металлын агууламж, мг/л					
	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
ус	0.15	0.00	0.0	0.041	0.102	0.058*
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4586:1998						
Хүлцэх агууламж	0.01	0.01	0.00	0.01	0.01	0.01

Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно  
 ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (MNS ISO 8288:1999, Атом шингээлтийн спектрометрээр.)

Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ:

С.НЯМДАШ MSc  
 Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК  
 ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
 дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
 Утас: (976)-99176123, 99231836  
 E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/11-10/2

Захиалагч: “Мэжик бриджит” ХХК  
 Дээж авсан цэг: Дундговь аймаг, Өлзийт сум  
 Сорьц авсан огноо: 2025 оны 11 сар 03 өдөр  
 Шинжилгээ хийсэн огноо: 11 сарын 10

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж 1											
1	0-30	8.46	0.153	0.363	0.67	2.24	1.46	8	9	0.6	9

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1								
1	0-30	12.9	65.6	9.4	6.7	1.1	4.3	12.1

3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1	0-30	5.0	12.5	0.0	38.2	1.9	8.6
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
	Элсэрхэг хөрс	60	50	1	100	60	60
	Шавранцар хөрс	100	70	1.5	150	80	100
	Шаварлаг хөрс	150	100	3	300	100	150

\*Харгалзах түвшин \* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна.

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Хүнд металлуудыг - хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: *S. Olgoo* ХУУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: *Mus* Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор